

## МОНГОЛЫН БАЙЛДАН ДАГУУЛЛЫН ТҮҮХ ТАЙВАНИЙ ТҮҮХ СУДЛАЛД

Н.Ариунгуа\*

XIII зууны Монголын байлдан дагуулал, Монголын эзэнт гүрэн байгуулагдсан түүхэн үйл явдал эрт дээр үеэс түүхчдийн анхаарлын төвд байсаар ирсэн билээ. Монголын байлдан дагуулал улс үндэстнүүдийн түүхэнд ямар үр дагавар авчирсан талаарх судалгаа монголчуудын ноёрхолд өртсөн орнуудын түүх судлалд онцгой байр эзэлдэг. Тухайлбал Хятадын түүх судлалд Монголын байлдан дагууллын үр дүнд тогтсон Юань гүрний түүх нэлээд судлагдсан нь Хятад улс Монголын эзэнт гүрний төв байснаас гадна Хятад улс түүхэндээ анх удаа бүхлээрээ харийн түрэмгийлэлд орсонтой холбоотой. Хятадын түүх судлалд Хятад дахь монголчуудын засаглалын талаарх үзэл баримтлал бүр Юань гүрний үед бий болсон. Үүнийг хятадын бичгийн хүн Сюй Хэн өөрийн зохиолдоо Юаний засаглалыг хууль ёсны хэмээн тодорхойлсноос харж болох юм. Тэрээр “Хуа<sup>1</sup> болон И<sup>2</sup> нар нь хоорондоо огт ялгаагүй бөгөөд И нар ч хятад аргаар төрийг барьж хаан ор сууж чадмой. Иймээс Юань нь Сүн улсын залгамжилсан төр улс мөн хийгээд түүнийг хууль ёсны хэмээн үзнэ гэжээ. Энэхүү Сюй Хэн хэмээгч нь Юаний ордонд алба хашиж байсан түшмэл учир түүний байр суурь ийм байхаас ч аргагүй байжээ. Харин Юань улс мөхөж Хятадын төр улс Мин байгуулагдсаны дараа Хятадын түүх судлалд хятад болон бүдүүлгүүд хоорондоо ялгаатай. Хэдий бүдүүлгүүд тэнгэр доорхийг /Хятад улсыг хэлж байна. Н.А./нэгтгэж чадсан боловч тэдний засаглалыг хууль ёсны гэж нэрлэж үл болмой гэжээ. Энэхүү үзэл баримтлал Хятадын түүх судлалд цаашид уламжлагдсаар өнөөг хүрчээ. Хятадын түүх судлал нь их газрын Хятад болон Тайваний хэмээн хоёр хуваагддаг. Өнөөгийн их газрын Хятадын түүх судлал нь Монголын байлдан дагуулал түүний үр дүнд тогтсон Юань гүрний талаар огт өөр үзэл баримтлалтай билээ. Тэрхүү үзэл баримтлалын дагуу Монголын байлдан дагуулал нь Хятад үндэстний нэг болох монгол үндэстний хийсэн аян дайн бөгөөд тэдний байгуулсан төр улс нь хэдэн зуун жил тархай бутархай байсан Хятад улсыг нэгтгэн нэг жолоонд оруулснаар Хятадын түүхийн хөгжилд асар их түлхэц өгсөн ажээ<sup>3</sup>

Харин Тайваний түүхчид Хятадын уламжлалт үзэл баримтлал дээр үндэслэн судалгаагаа цаашид үргэлжлүүлэн хөгжүүлсэн байдаг. Бид энэхүү илтгэлдээ Тайвань дахь Юань гүрний түүхийн судлалын талаар өгүүлэх болно.

Тайваньд Юань гүрний судлал 1949 оноос хойш үүссэн ба түүнийг үндэслэгч бол Яо Цун У түүхч юм. Тэрээр 1949 оноос өмнө Хятадын нэрт түүхчид болох Вэнь Дузын, Хань Сюлин, Шао Дунжэн нарын хамт их газрын Хятадад Монголын түүхийн судлалаар судалгаа хийж байгаад Хятадад гарсан

\* Н.Ариунгуа – ОУСХ-гийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

ардын хувьсгалын үеэр Тайваньд суурьшиж Юань гүрний судлалыг үндэслэсэн болно. Тайвань дахь Юань гүрний судлалаар анх судалгаа хийж эхэлсэн түүхчид тухайлбал Яо Цун У нарын судалгааны гол үзэл баримтлал бол XIII зууны монголчууд нь Хятад улсын хувьд харийн эзлэн түрэмгийлэгчид байсан хийгээд тэдгээрийн төр улс нь түрэмгий шинжтэй гэж үзэж байжээ. Судалгааны чиглэл нь гол төлөв Юань гүрний үеийн хятадын бичгийн хүмүүн болон гүшмэлүүдийн тухай судалгаа юм. Учир нь Хятадын түүхийн бүхий л үед энэхүү нийгэм улс төрийн давхарга нь маш нөлөө бүхий байсаар ирсэн бөгөөд тэдгээрийн улс төрийн дэмжлэггүйгээр засаг төрийг тогтвортой удаан хугацаанд барих бололцоогүй байжээ. Энэхүү давхрагын нийгэм –улс төрийн байдал Юань гүрний үед хүнд хүчир байсан зэрэг нь судалгааны бүхэл бүтэн чиглэлийг бий болгосон ба Тайваний эрдэмтдийн энэ чиглэлээр хийсэн судалгаа олон улсын Юань гүрний судлалд өнгөлсөөр байгаа юм.

Хятад улс харийн ноёрхолд анх удаа бүхлээрээ орсон нь Хятадын нэр хүндэд маш том цохилт болсон нь дамжиггүй. Тэр үеэс хойш хэдэн зуун жил улиран өнгөрсөн боловч Монголын байлдан дагуулалд хандах хандлага маш эмзэг хэвээр байгаа бөгөөд үүнийг Тайвань дахь Юань гүрний түүх судлалаас харж болох юм. Тухайлбал Тайваний түүх бичлэгт Юань гүрний түүхийг огт өгүүлэхгүй тэр чигээр нь орхигдуулах тохиолдол нэлээд газар авсан юм. Энэ нь ялангуяа салбарын түүхэнд элбэг тохиолддог. Ийнхүү түүхийн бичлэгт бүхэл бүтэн үеийн түүхийг сох дутааснаар Хятадын түүхийн хөгжлийг тасралтгүй бүтнээр нь гаргах бололцоогүй болдог. Үүнийг ч Тайваний зарим түүхчид шүүмжилсээр иржээ.<sup>4</sup>

Орчин үеийн Тайваний түүх бичлэгийн гол онцлог бол Монголын эзэнт гүрнийг зөвхөн Хятад улсын түүхийг судлах хүрээнд судалдаг. Энэ нь эхэн үеийн түүхчдэд хамааралтай хэдий ч орчин үед ч Тайваний судлаачид энэхүү байдлаасаа ангижирч аанай чадаагүй байгаа болно.

Тайваньд Юань гүрний түүхээр хамгийн түлхүү судлагдсан сэдвүүдэд Хятад дахь Юаний засаглалын шинж чанар, Юань гүрний Хятадын түүхийн хөгжилд үзүүлсэн нөлөө, үр дүн, Юань гүрний үед монголчуудын хятадчилагдсан байдал, хятад монгол үзэл санааны ялгаа, Юань гүрэн мөхсөн шалтгаан зэрэг асуудлууд хамаарагдана.

Юань гүрний засаглалын шинж чанарын талаарх уламжлалт үзэл баримтлалын тухай бид дээр товч дурьдсан билээ. Харин олоо Тайваний орчин үеийн түүх судлалд Юань гүрний засаглалын шинж чанарыг хэрхэн авч үздэг талаар өгүүлье. Энэ нь Тайваний түүхчдийн байнга хөнддөг асуудлуудын нэг бөгөөд энэ сэдвээр нэлээд дорвитой судалгаа хийсэн хүн бол Тайваний түүхч Сяо Цицин юм. Тэрээр Юань гүрэн байгуулагдсанаар Хятадад нэгдсэн төр улс бий болсон мөн чанарын тухай асуудлыг авч үзээд Юаний засаглал хууль ёсны бус гэсэн дүгнэлт хийж шалтгааныг нь дурьдсан байна: Нэгдүгээрт Юань гүрэн Хятадыг нэгтгэсэн байдал, засаглалыг тогтоосон арга хэлбэр нь Хятад үндэстний уламжлалт хэв маягаас тэс өөр. Юуны өмнө тэрхүү засаглал

нь хоёрдмол шинжтэй. Хубилай Сүн улсыг мөхөөж Хятадыг нэгтгэн төр улсаа байгуулахдаа хэзээ ч Хятад улсын нэгдлийг хангах туйлын зорилт тавиагүй бөгөөд Хятадын эсрэг хийсэн аян дайн бол монголчуудын дэлхийг эзлэх гэсэн аян дайны үргэлжлэл байсан. Хоёрт монголчуудын засаглал дарангуй хэв маягтай хийгээд тэдний улс төрийн туйлын зорилго бол “цөөхөн монголчууд”-ын ноёрхлыг аль болохоор урт удаан хугацаанд тогтоох. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд үндэстэн угсаагаар нь ялгаварлан салгах нарийн бодлого хэрэгжүүлж байв. Үндэстэн бүрийн соёл, ёс заншлыг хүндэтгэнэ, шашин бүрийг ялгаварлахгүй дэмжинэ гэсэн бодлого нь үнэн чанартаа үндэстнүүдийг ёс заншил, шүтлэг бишрэлээр нь хуваах аргаар тус тусад нь барьж байх нарийн бодлого байв. Энэхүү бодлого нь Африк, Латин Америкийн улс үндэстнүүдийн талаар явуулж байсан колони бодлоготой агаар нэгэн буй гэжээ.<sup>5</sup>

Тайваний нэрт судлаач Ян Мэн Ү “Хятадын улс төрийн сэтгэлгээний түүх” хэмээх зохиолдоо мөн энэ асуудлыг хөндөн дурьдсан байх нь: Хань Тан<sup>6</sup> улсуудын үед дөрвөн зүгийн бүдүүлгүүдийг захиргаандаа оруулсан учир “тэнгэр дор нэгэн гэр бүл” гэсэн үзэл санааг дэвшүүлж байв. Үүний гол зорилго бол харь үндэстнүүдийн эсэргүйцлийг дарах улс төрийн зорилготой байсан. Харин Юань гүрний үед дахин ийнхүү ярих болсон нь Хятад улс өөрөө харь үндэстэнд эзлэгдсэн учир Хятадын улс төрчид, гүн ухаантнууд /бичгийн хүмүүс/ бүдүүлгүүд болон хань үндэстний хоорондын ялгаа чухал биш гэсэн санааг илүүтээ дэвшүүлж бүдүүлгүүдийг өөрчилж тэднийг хятадчилах бодлого баримтлах болсон юм. Иймээс “хятадууд бүдүүлгүүдийн ёс заншлаар бүдүүлгүүдийг захирч байсан бол бүдүүлгүүд Хятадыг эзлэн авснаар хятад ёсоор Хятадыг захирна” гэсэн санааг өргөн дэвшүүлэх болов. Гэвч хэдий монголчууд Хятадын улс төрийн системийг өвлөн авч, монгол өнгөт нүдэт үндэстнүүд хятад хүмүүстэй холилдон амьдарч байсан боловч Монголын хаад монгол зан заншлаа чандлан сахин хадгалж хятад бичиг үсгийг сурахыг төвдөхгүй байв<sup>7</sup>. Монголын эзлэн түрэмгийлэгчид зөвхөн өөрсдийн эрх ашгийг хамгаалж хятад үндэстэнд маш их гай зовлон авчирсан учир хятадууд тэдэнтэй нэгдэн уусахыг эсэргүйцсээр байв<sup>8</sup> гэжээ.

Юань гүрний үед монголчуудын хятадчилагдсан байдлын талаар Тайваний түүхчид нэлээд судалсан байдаг. Тэд нар Юань гүрний үед монголчууд маш бага хятадчилагдсан гэдэгтэй бүгд санал нэгтэй байдаг боловч монголчуудын тийнхүү бага хэмжээгээр хятадчилагдсан нь Хятадын түүхийн хөгжилд ямар үр дагавар авчирсан талаар харилцан өөр өөр үзэл баримтлалтай ажээ. Зарим түүхчид, тухайлбал Ван Мин Сүн түүхч монголчууд ийнхүү бага зэргээр хятадчилагдсан нь Хятад улсад хор хөнөөл ихээр учруулаагүй гэсэн санаа дэвшүүлсэн байна. Тэрээр Зүрчидийн Алтан улс, манж Чин улсын үед Хятадын оюун санаа, бичиг үсэгт учирсан хор хохирол үлэмж билээ. Энэ нь тэрхүү харийн хоёр төр улс нь гүнзгий хятадчилагдсантай ч холбоотой байж магад. Гэтэл Киданы Ляо улс, Юань гүрний үед ийм тохиол учирсангүй. Магад энэ нь тухайн хоёр төр улс нь маш бага хятадчилагдсантай холбоотой<sup>9</sup> гэжээ.

Бидний дээр дурьдсан судлаач Ян Мэн У өөрийн “Хятадын улс төрийн сэтгэлгээний түүх” зохиолдоо мөн сонирхолтой санаа дэвшүүлсэн байдаг нь:” Хэдий монголчууд Хятадын улс төрийн системийг хэрэглэж хэдэн 10 жил Хятадыг ноёрхож байсан боловч монгол хүмүүс хятадуудаас ялгаатай хэвээр байсан юм. Монголын хаант төр монгол ёс заншлыг уйгагүй хамгаалсаар ирсэн учир ард түмэн монголчуудын эсрэг бослого гаргасан Цин Хань улсуудын дараа харь үндэстнүүд Хятадын тал газар руу цөмрөн орж ирж хятад үндэстний дэвжин хөгжихөд хувь нэмрээ оруулсаар байв. Хятад үндэстэн нь дөрвөн зүгийн бүдүүлгүүдтэй харьцуулваас соёлын хувьд хөгжингүй байсан учир харь үндэстний түрэмгийллээс үл айв. Харин харь үндэстэн бидэнтэй уусан нэгдэхгүй байх бий хэмээн эмээсээр ирэв”<sup>10</sup> гэжээ. Түүхч Сяо Цицин монголчууд Юань гүрний үед хятадчилагдаагүй харин “иргэншсэн” /literatization/ гэжээ. Тэрээр “хятадчилагдах” болон “иргэншсэн” гэсэн хоёр ойлголтын ялгааг ийнхүү тайлбарласан нь “хятадчилагдана” гэдэг нь өрийн уугуул ёс заншлаа бүр мөсөн гэж хятад үндэстэнтэй нэгдэн уусах явдал юм” харин “иргэншинэ” гэдэг маань өөрийн уугуул ёс заншлаа гээхгүйгээр хадгалж зөвхөн “бичиг номын соёлыг” авахыг хэлнэ гэжээ.

Юань гүрний дунд болон хожуу үед монголчууд хийгээд өнгөт нүдтэнгүүд хятадчилагдаагүй зөвхөн “иргэншсэн” бөгөөд харин Мин улсын үед Хятадад үлдсэн монголчууд жинхэнэ утгаараа хятадчилагдсан болно<sup>11</sup> гэжээ.

Ийнхүү Тайваний түүхчид Юань гүрний үед монголчууд хятадчилагдсан асуудлын талаар маш олон санаа дэвшүүлсэн байна. Харамсалтай нь тэдний судалгаанд чухам ямар учраас монголчууд Юань гүрний үед хятадчилагдаагүй вэ гэсэн асуултыг огт хөндөөгүй байдаг. Гэтэл энэхүү асуултанд хариулснаар сая монгол үндэстний өвөрмөц чанар, үндэсний ухамсар, Юань гүрний хаадын алсыг харсан бодлогын мөн чанар зэргийг ойлгоход дөт болох юм. Хэрэв хятадууд монголчууд хятадчилагдахгүй нь хэмээн айж байсан бол монголчууд хятадчилагдахаас хамгийн ихээр болгоомжилж байсан болно. Учир нь Хятадыг эзлэн авч тэндээ уусан замхарсан урьдны нүүдэлчдийн гашуун түүхэн туршлага тэдэнд нэгийг өгүүлж байсан нь даамжиггүй юм.

Хятад дахь Монголын ноёрхол унасан шалтгааны талаар Тайваньд мөн багагүй судалгаа байдаг. Тэдгээр судалгаануудад Юань гүрний мөхсөн явдлыг маш олон талаас тайлбарлахыг оролджээ. Юуны түрүүнд тэрхүү шалтгааныг монголчууд хятадчилагдаагүйтэй холбон тайлбарласан байдаг. Тухайлбал харь үндэстнүүд хятадчилагдахгүй тохиолдолд 100 жил хүрэлгүй устдаг гээд харин манж нар 200 гаруй жил оршин тогтносон нь тэд аажмаар хятадчилагдаж Күнзы, Мэнзын зохиол бүтээлийг уншиж, хятад хэлээр ярьж байсантай холбоотой<sup>12</sup> гэжээ. Нөгөөтэйгүүр монголчуудын ийнхүү 100 хүрэхгүй жил тогтносныг хятадуудын талаар явуулж байсан ялгавартай харгис бодлогтой холбон тайлбарласан байдаг<sup>13</sup>. Харин нэрт түүхч Лао Гань “Хятадын түүхийн хөгжлийн мөчлөг ба үечлэл” өгүүлэлд Юань гүрэн мөхсөнийг хоёр төрлийн шалтгаанаар тайлбарласан байдаг. Нэгдүгээрт Хатан гол болон Чанзян голуудын сав газар

нь байнга байгалийн гамшиг тохиолддогийн учир хүн ард нь өлсгөлөнд нэрвэгдэн бослого гаргаж төр засгаа авч хаядаг ажээ. Яг тийм өлсгөлөнгөөс үүссэн ард түмний бослого Юань гүрний хожуу үед тохиолдсон нь түүний мөхлийн нэг шалтгаан болсон хэмээсэн байна. Хоёр дахь шалтгаан бол Хятадын түүхэнд гурван маш өвөрмөц хувь тохиолтой төр улс байдаг ба тэдгээр нь Цин, Суй, Юань юм. Тэдгээр улсуудын нийтлэг онцлог бол улс төрийн бутралыг эцэслэн Хятадыг нэгтгэсэн юм. Тэдний орчин тойронд өрсөлдөгч дайсан улс байхгүй байсан учир үр дүнтэй шинэчлэлийг ямар ч гадаад дотоогын дарамтгүй хэрэгжүүлэх бололцоотой байв. Гэвч түүнийгээ хэтрүүлэн бодит байдлаасаа хөндийрсэн учир улс төрийн хувьд хүнд байдалд орж тэр нь мөхлийн нь шалтгаан болсон ажээ. Юань гүрний хувьд гэвэл тэрээр ач холбогдол бүхий өөрчлөлт шинэчлэл нэг их хийгээгүй учир харьцангуй удаан оршин тогтносон байна. Нөгөөтэйгүүр хэдий монголчууд хятадуудын хувьд харь үндэстэн байсан ч гэсэн нөгөө хоёр улсыг бодвол ард иргэдэд арай энэрэнгүй хандаж байсан нь тэдний оршин тогтнох хугацаанд зэрэгээр нөлөөлсөн. Юань гүрний хувьд Монголын ихэнхи хаад Хятадын онцлогийг үл ойшоон нүүдлийн нийгмийн арга барилаасаа салж төвдөхгүй эхнээсээ аваад дуустал Хятадын түшмэл анги бичгийн хүмүүсийг ялгаварлан гадуурхсны улмаас тэдний зүгээс дэмжлэгийг эс олсон зэргээс мөхсөн юм<sup>14</sup> гэжээ.

Ийнхүү Тайваний ихэнхи түүхчдийн судалгаанаас харахад Монголын Юань гүрэн мөхсөн шалтгаан нь гол төлөв монголчууд өөрийн ёс заншлаа хадгалан тэр бүр хятадчилагдаагүйтэй холбоотой байна.

Хятад монгол үндэстнүүдийн улс төрийн сэтгэлгээний ялгаа, онцлогийн асуудал бол Юань гүрний судлалд маш сонирхол татсан сэдвүүдийн нэг юм. Тайваний түүхчид энэ талаар мөн тодорхой хэмжээний судалгаа хийсэн байна. Тэдгээрийн гол санааг базан дурдвасаас “монголчууд Хятад улсыг засан захирахдаа хятад аргыг хэрэглэхийн зэрэгцээ мөн монгол ёс заншлаа хэвээр нь хадгалж байсан учир эхнээсээ аваад дуустал хятад монгол арга барилын зөрчил тасралтгүй үргэлжилсээр байв<sup>15</sup> гэжээ. Нөгөөтэйгүүр монголчууд хятад хүмүүсийг бодвол хийсвэр сэтгэлгээгүй, гүн ухааны гүн руу орж энэ тэрийг эрэгцүүлэн суухгүй, шууд л хэрэгжүүлдэг учир тэдний оюун санаанд Сыма Гуанийх\* шиг бодол орж ирж байсан нь юу л бол. Тэд хятад ухаан, хятад аргыг зөвхөн улс төрийн зэвсэг болгон хэрэглэж байсан ба тэдэнд Хятадын гүн ухаан, соёл зан заншлыг жинхэнэ утгаар нь авах шаардлага ч байгаагүй<sup>16</sup> гэжээ.

Юань гүрний ноёрхол Хятадын түүхийн хөгжилд үзүүлсэн нөлөөллийн асуудал хамгийн чухал бөгөөд маргаантай асуудлуудын нэг юм. Юань гүрний Хятадын түүхийн хөгжилд үзүүлсэн нөлөөллийг Тайваний түүхчид хоёр хэсэгт авч үздэг бөгөөд нэг нь ойрын нөлөөлөл, нөгөө нь алс хэтийн гэж хоёр хуваадаг байна.

Бид энэхүү илтгэлдээ зөвхөн алс хэтийн нөлөөллийн талаар өгүүлэх болно. Тайваний түүхчдийн дотор Юань гүрний ноёрхол Хятадын түүхийн

\* Сыма Гуань бол Хятадын нэрт гүн ухаантан



хөгжилд алсдаа ямар нөлөө үзүүлсэн талаар санал нэг биш байдаг. Зарим түүхчид Юань гүрэн Хятадын тархай бутархай байдлыг эцэс болгож Мин, Цин улсуудын хамт нийтдээ 600 жил Хятадыг нэгдмэл орших үндсийг тавьсан хэмээн үздэг<sup>17</sup>. Тэгвэл зарим түүхчид, тухайлбал Сяо Цицин Юань гүрний ноёрхол Хятадын цаашдын хөгжилд маш муугаар нөлөөлсөн хэмээн үзжээ. Тэрээр монголчууд Хятадыг булаан эзэлж авснаар Тан Сүн улсын үед Хятад улсын эдийн засаг-нийгмийн хөгжлийн салбарт нэгэнт эхэлсэн аугаа их өөрчлөлт буюу “эртний нийгмээс орчин үеийн нийгэмд шилжих” үйл явц зогсч Хятад буцаад хуучин нийгэмдээ шилжин орсон. Хэдий энэ үйл явц манж Чин улсын үед дахин сэргэсэн боловч Монголын эзэнт гүрний үед ийнхүү саатан зогссоноор Хятадын хөгжилд маш их гарз учирсан<sup>18</sup> гэжээ. Энэхүү санааг суллаач Тун Вэй үргэлжлүүлэн Юань гүрний үед Хятадын соёл “шоронд талхигдаж байсан” гээд монголчуудын сайн танил Хятадын зохиолч Лу Синийг иш татан Хятад улсын олон зуун жилийн хоцрогдол нь зэрлэг бүдүүлэг монгол манж үндэстнүүдийн эзлэн түрэмгийллээс болсон хэмээн бичжээ<sup>19</sup>. Хубилай хааны түүхэн үнэлгээний асуудал бол Юань гүрний судлалд маш чухал сэдвүүдийн нэг юм. Гэвч Тайваньд энэ чиглэлийн судалгаа маш цөөхөн бөгөөд энэ нь Хубилай хааны талаархи эерэг бус хандлагатай холбоотой боловч уу. Хэдий тийм боловч Хубилай хааны үйл ажиллагааг өндрөөр үнэлсэн мэр сэр судалгаа байдаг бөгөөд тухайлбал Чэнь Хуйжу судлаач Хубилай хааныг Хятад иргэншлийг тал нутгийн соёлтой хослуулан төр барих загварыг амжилттай бий болгосон суутан хэмээн өндрөөр үнэлсэн байдаг<sup>20</sup>.

Хубилай хаантай холбоотой мөн сонин таамаглал бүхий судлагаа байдаг. Тухайлбал Сяо Цицин хэрэв Хубилай Аригбух хоёрын Монголын хаан суудлын төлөөх тэмцэлд Аригбух ялсан бол Монголын эзэнт гүрний төв Монголд байх бөгөөд Хятад монголчуудын түрэмгийлэлд өртөхгүй байсан хэмээн бичжээ<sup>21</sup>. Гэтэл угтаа Хятадын эсрэг аян дайн бол юуны түрүүнд дэлхийг эзлэх гэсэн монголчуудын аян дайны нэг хэсэг байсан хийгээд нөгөөтэйгүүр нүүдэлчин улсууд өмнө зүг рүү түрэмгийлдэг үндсэн шалтгаанаас улбаатай билээ.

Ийнхүү бид Тайваний Юань гүрний судлалд байдаг зарим судалгаа үзэл баримтлалын талаар товч дурдан танилцуулав. Үзэл баримтлалын хувьд дээрхи судалгаа нь өвөрмөц байхын зэрэгцээ бие даасан судалгааны чиглэл бүрэлдэн бий болсныг харуулж байна. Судалгаанд нь гол төлөв улс төрийн судалгааны чиглэл давамгайлдаг ба энэхүү судалгааны гол онцлог бол өгүүлж буй үеийн монголчуудыг харь үндэстэн хэмээн үзэж тэдний хийсэн аян дайныг эзлэн түрэмгийлэх аян дайн хэмээн үзсэнд оршино. Энэхүү үзэл баримтлал нь манай монголын түүх судлалын үзэл баримтлалтай ойр юм. Нөгөөтэйгүүр тайваний түүхчдийн судалгаанд зарим нэгэн хэт нэг талыг баримталсан, шүүмжлэл даахгүй үзэл баримтлал байдгийг тэмдэглэхийн зэрэгцээ тэдний дэвшүүлж буй зарим нэгэн санааг цааш нь мөн лавшруулан судлах шаардлагатай мэт. Тухайлбал Их Монгол улсын үед үндэстэн ястан, шашин шүтлэг үл харгалзан зэрэгцэн орших гэсэн монголчуудын дэлхийн хэмжээний хэв журам Хятадын

хөрсөн дээр хэрхэн яаж бууж хэрэгжиж байсан бэ гэсэн асуудлыг монголын түүхчид өөрсдөө судлавал бас өөр гаргалгаа гарч болох. Энэ мэтээр манай түүхчид Монголын Юань гүрний түүхийг монголчуудын дэлхийн тавцанд үлдээсэн ул мөр буюу Монголын эзэнт гүрний аугаа түүхийн үүднээс илүү өргөн хүрээнд судлах нь Монголын түүхийн шинжлэх ухааны гол зорилтуудын нэг болоод байна.

## ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

<sup>1</sup> Хань үндэстнийг хэлж байна

<sup>2</sup> Хятад бус үндэстнүүдийг ийнхүү нэрлэж байжээ

<sup>3</sup> Линь Гань, Ма Дажэн, Бүянхүү Өвөр Монголын түүх ба соёл. Хөх хот 2000

<sup>4</sup> Сяо Цицин. Юань гүрний үеийн үндэстнүүдийн соёл ба бичгийн хүмүүс. Тайбэй 2008. Оршил

<sup>5</sup> Сяо Цицин юань гүрний талаархи шинэ судалгаа. Тайбэй, 2006

<sup>6</sup> Хятадын нэгдсэн төр улсууд

<sup>7</sup> Ян Мэн У. Хятадын улс төрийн сэтгэлгээний түүх. Тайбэй 1982, т.452

<sup>8</sup> Мөн зохиол т.558

<sup>9</sup> Ван Мин Сун. Юань гүрний үеийн бичгийн хүн ба улс төр. Тайбэй. 1992, т.310

\* Хятадын нэгдсэн төр улсууд

<sup>10</sup> Ян Мэн У. Хятадын улс төрийн сэтгэлгээний түүх, т.398

<sup>11</sup> Сяо Цицин. Юань гүрний соёл ба бичгийн хүмүүс Тайбэй, 2008

<sup>12</sup> Ян Мэн У. Хятадын улс төрийн сэтгэлгээний түүх, т.189

<sup>13</sup> Юань Зи. Юань улсын түүх. Өгүүллүүдийн эмхтгэл. Тайбэй. 2007, т.69

<sup>14</sup> Лао Гань. Хятадын түүхийн хөгжлийн мөчлөг ба үечлэл. – Зохиолын эмхтгэл. Тайбэй 2006, т.13-17

<sup>15</sup> Ли Ши. Сун, Ляо, Зин, Юань улсуудын түүхийн тухай өгүүллүүдийн эмхтгэл. Тайбэй 1991, т.30-31

<sup>16</sup> Ван Мин Сун. Дээр дурьдсан зохиол, тал 315-316, 139,140

<sup>17</sup> Жан Юн Шэн. Хятадын эртний соёл, эдийн засаг. Тайбэй 2007, т.189

<sup>18</sup> Сяо Цицин. Юань гүрний үеийн үндэстний соёл ба бичгийн хүмүүс / Тайбэй 2008, т.22

<sup>19</sup> Тун Вэй. Хятадын түүхэн дэх том алдаа. Тайбэй 2006, т.207, 210

<sup>20</sup> Чэнь Хуйжу. Ази Европыг доргиосон Хубилай. Тайбэй 1980, т.1

<sup>21</sup> Сяо Цицин. Юань гүрний түүхийн талаарх шинэ өгүүллүүд. Тайбэй. 2007, т.16